

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2022 ОНЫ ХАМТ (ТАРИФ)-ЫН
ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

2022 оны 12 дугаар сарын 13

Заалт №	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах газар	Биелэлт	Биел элтий н хувь	Тайлбар 1,2
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮИЛ					
1.2	Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, тэдгээрийн харьяа байгууллага, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь хууль, эрх зүйн хүрээнд бодлого шийдвэрээрээ хэрэгжүүлж ажиллах үүрэг хүлээнэ.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо -Эрүүл мэндийн байгууллагууд	Гурван талаас хамтын хэлэлцээрийг эмнэлгүүд мөрдөн хэрэгжүүлж байгаа ба тус эмнэлэг Үйлдвэрчний эвлэлийн хороотойгоо хамтран ажиллаж байна.	100%	
1.3	Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд нь тус хэлэлцээрт заагдсан нөхцөл баталгаанаас дордуулсан тушаал, шийдвэр гаргасан тохиолдолд энэхүү хэлэлцээр эсвэл байгууллагын хамтын гэрээг дагаж мөрдөнө.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Эрүүл мэндийн байгууллагууд	Эмнэлэг нь тус хэлэлцээрт заагдсан нөхцөл баталгаанаас дордуулсан тушаал, шийдвэр гаргасан тохиолдол гаргаж ажиллаагүй болно.	100%	

ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР

2.4	Ажил олгогч нь хөдөлмөр зохион байгуулалт нь өдрөөр ажиллах горимтой эмч, ажилтнууд илүү цагаар болон дуудагдаж ажилласан, жижүүрт гарч ажилласан тохиолдолд биеэр амруулаагүй бол илүү цагийн хөлсийг ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн зүйл, заалтын дагуу тооцож олгоно.	-Санхүү, эдийн засгийн газар -Эрүүл мэндийн байгууллагууд	- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1,581,542,311 төгрөгийг давхардсан тоогоор нийт 2,970 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. - Дуудагдан ажилласны хөлс болох 80,130,160 төгрөгийг давхардсан тоогоор нийт 1,796 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.	100%	
2.5	Ажил олгогч нь эрүүл мэндийн байгууллагын үйлчлэгч, туслах сувилагчийг богино хугацааны сургалтад үе шаттай хамруулж ажиллана.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Бодлого төлөвлөлтийн газар -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо -Эрүүл мэндийн байгууллагууд	Халдварын сэргийлэлт хяналтын мэдлэг дээшлүүлэх чиглэлээр 2 удаагийн сарын аян, 3 удаагийн өдөрлөг, 20 сэдвээр 700 эрүүл мэндийн ажилтанд 29 удаа сургалт зохион байгуулагдсан. Үүнд туслах сувилагч, үйлчлэгч нар 100% хамрагдсан. "Эрүүл мэндийн ажилтны өртөлт" сэдэвт сургалтыг нийт 50 эрүүл мэндийн ажилтанд 2 удаа зохион байгуулсан. 5 дугаар сарын 4-ны өдөр 1 удаа, 06 дугаар сарын 23-ны өдөр Солонгосын КОFИН төслийн санхүүжилтээр 25 сувилагч, 5 туслах сувилагч, 20 үйлчлэгч нарт сургалт зохион байгуулсан. Туслах сувилагч С.Дэлгэрбуян, Т.Нандинцэцэг нар ХӨСҮТ дээр зохион байгуулагдсан ариутгагчийн мэргэжил олгох 3 сарын сургалтанд хамрагдсан. 2022 оны 7 дугаар сарын 29-нд, 8 дугаар сарын 5-нд тус бүр ажлын байран дээрхи сургалтыг Солонгосын КОFИН төслийн санхүүжилтээр болон төсгийн төсөвөөр 2 удаа зохион байгуулж ЭМЯ-ны	100%	

			харъяа 16 эрүүл мэндийн байгууллагын ариутгагч нарыг оролцуулсан. Нийт 50 ариутгагч хамрагдсан.		
2.6	Тодорхой шалтгааны улмаас ажлын байрыг олноор цөөрүүлэх, шилжүүлэх, орон тоо, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ ажил олгогч нь ҮЭ-ийн байгууллагад 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг сонирхлыг хангаж ажиллана.	-Эрүүл мэндийн байгууллагууд - Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	- Тайлант хугацаанд Хөдөлмөрийн тухай хуулийн 80, 81 дүгээр зүйлийн хүрээнд байгууллагын бүтэц, орон тоо, ажлын байрыг цөөрүүлэх, ажлын байр хасагдсан зохион байгуулалттай холбоотой хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай асуудал гараагүй болно. - Хөдөлмөрийн тухай хуулийн 58, 59 дүгээр зүйлийн хүрээнд Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны Б/22, Б/23, Б/51, Б/55, Б/109, Б/121, Б/154, Б/177, Б/220, Б/241, Б/339, Б/354, Б/384, Б/425 дугаар тушаалаар нийт 28 эмнэлгийн тусламж, үйлчилгээний зайлшгүй шаардлагаар хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалах үүднээс эмнэлгийн ажилтныг өөр тасаг, нэгжид шилжүүлэн болон сэлгэн ажиллуулсан.	100%	
2.7	Энэхүү хэлэлцээрийн 2.6-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 3 жил хүртэл хугацаа дутуу байгаа ажилтан, өрх толгойлсон болон насанд хүрээгүй 2-оос дээш хүүхэдтэй ажилтнуудыг цомхотголд хамруулахгүй байх бөгөөд хэрэв тухайн ажлын байр нь зайлшгүй цомхотголд орсон тохиолдолд өмнө нь авч байсан цалин хөлс, хөдөлмөрийн нөхцлийг бууруулахгүйгээр өөр ажлаар хангана.	-Эрүүл мэндийн байгууллагууд	Хэлэлцээрийн 2.6-д заасан нөхцөл байдал үүсээгүй болно.	100%	

2.9	Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга болон идэвхтэн, сонгуультнуудыг тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулан ажлаас нь чөлөөлөхгүй, тогтвор суурьшилтай ажиллуулна.	-Эрүүл мэндийн байгууллагууд - Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	Эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга болон идэвхтэн, сонгуультнуудыг тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулан ажлаас нь чөлөөлөөгүй.	100%	
2.10	Эрүүл мэндийн салбарын мэргэшсэн эмч, ажилтнууд болон Үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн, сонгуультнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг баримталж удирдлагын хувийн үзэл бодол, улс төр. намын үзэл бодлоор ажлаас нь чөлөөлөхгүй байна.	-Эрүүл мэндийн байгууллагууд	Эмнэлгийн мэргэшсэн эмч, ажилтнууд болон Үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн, сонгуультнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг баримталж ажилласан бөгөөд Удирдлагын хувийн үзэл бодол, улс төр, намын үзэл бодлоор ажлаас нь чөлөөлсөн тохиолдол байхгүй.	100%	
2.11	Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын нэг өдрийн ажлын цагийн үргэлжлэх хугацааг ээлжийн хуваарьтай уялдуулан хөдөлмөр зохион байгуулалтыг өөрчлөн боловсронгуй болгох талаар санал боловсруулж хамтран ажиллана.	-Бодлого төлөвлөлтийн газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	ЭМНЭЛЭГТ ХАМААРАЛГҮЙ		
2.12	Ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхэд Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргын оролцоог хангах үүднээс Удирдлагын багийн бүрэлдэхүүнд оруулна.	-Эрүүл мэндийн байгууллагууд	Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нь эмнэлгийн Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд орж, ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт болон эвлэлдэн нэгдэх эрхийг хангуулахын тулд эмнэлгийн тусламж, үйлчилгээ, төсвийн зарцуулалт, бүтэц, зохион байгуулалт, орон тоо болон хөдөлмөр эрхлэлтийн харилцаатай холбоотой бүхий л асуудлыг шийдвэрлэхэд оролцсон.	100%	
ГУРАВ. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТАЛААР					
3.7	Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг хамтран боловсруулж, батлуулж хэрэгжүүлнэ.	-Санхүү, эдийн засгийн газар -Монголын эрүүл мэндийн ажилтны	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 35 эмнэлгийн	100%	

		үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	мэргэжилтэн, ажилтанд 10%-иар тооцон нийт 22,870,655 төгрөг тооцон олгосон.		
3.12	Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос уламжлал болгон зохион байгуулдаг “Алтан чагнуур” шагналаар шагнагдсан эмчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг ажиллаж буй байгууллагаас нь олгоно.	-Санхүү, эдийн засгийн газар -Эрүүл мэндийн байгууллагууд	Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос уламжлал болгон зохион байгуулдаг “Алтан чагнуур” шагналд эмнэлгийн мэргэжилтнүүдээс нэр дэвшүүлж Яаралтай тусламжийн чиглэлээр тус эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч Ж.Уламсайхан шагнагдсан.	50%	
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАЛААР					
4.1	Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.5 дахь заалтуудыг одоо мөрдөж буй хүрсэн түвшнээс бууруулахгүй, ажилласан жилтэй уялдуулан төрийн өмчит эрүүл мэндийн байгууллага бүрэн олгоно.	-Санхүү, эдийн засгийн газар -Эрүүл мэндийн байгууллагууд	• Үндсэн цалин - Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 25, 276, 107 дугаар тогтоолын дагуу Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/37, А/89, А/90 дүгээр тушаалаар нийт ажилтны үндсэн цалинг 10%-иар нэмэгдүүлсэн. Ингэснээр илүү цаг, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллын хувь өсөж ажилтны гарт олгогддог цалин 15-40 хувиар нэмэгдэж байна. • Мэргэшлийн зэргийн нэмэгдэл- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 22.1 дэх заалтын дагуу эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 11, Зөвлөх эмч 12, Зөвлөх сувилагч 2, Тэргүүлэх эмч 38, Тэргүүлэх сувилагч-39, Ахлах эмч 29, Ахлах сувилагч 41, бусад мэргэжилтэн 4 нийт 176 ажилтанд боловсролын	100%	

			болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус тооцон 200,617,117 төгрөгийн нэмэгдэл олгосон • Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын дагуу нийт 296 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 313,875,346 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон. • Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл- Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1 дүгээр заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 147,628,418 төгрөгийг 187 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Нийтээр амрах баярын өдөр ажиллуулсан хөлс- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1,581,542,311 төгрөгийг эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Дуудагдан ажилласны хөлс болох 80,130,160 төгрөгийг эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. • Шөнийн цагийн нэмэгдэл хөлс- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай	
--	--	--	---	--

			хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 138,924 цагийн 138,924,000 төгрөг олгогдсон. • Алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэний нэмэгдэл хөлс- (Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Багахангай дүүрэг) Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт 8 эмнэлгийн мэргэжилтэн ажилтанд 372,876 төгрөг олгосон. • Нийтийн тээврийн унааны болон өдрийн хоолны олговор- Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын дагуу хоол, унааны нэмэгдэл 502,593, 000 төгрөгийг 546 ажилтанд олгосон. • Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам”-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2022 оны I улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 180,327,968 төгрөг, 2022 оны II улиралд 509	
--	--	--	--	--

			эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 191,285,364 төгрөг, 2022 оны III улиралд 506 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 165,355,960 төгрөг, 2022 оны IV улиралд 501 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 212,025,308 төгрөг олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны Б/164, Б/249, А/104, А/155 тушаалууд) • Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 35 ажилтанд 10%-иар тооцон нийт 22,870,655 төгрөг тооцон олгосон. • Хариуцлагын нэмэгдлийг 50 ажилтанд нийт 46,229,433 төгрөг тооцон олгосон. • Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл нь нийт 504 (3358 нийт хоногийн) эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтанд Ажил олгогчоос 59,505,348 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 34,869,349 төгрөгийн тэтгэмж олгосон. • Эмнэлэг сувилахуйн болон тусгай мэргэжилтний хомсдолд орж ажлын байрны ажлын ачаалал эрс нэмэгдсэнтэй холбоотой Ерөнхий захирлын 2022 оны А/99 дугаар тушаалаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сувилахуйн болон тусгай мэргэжилтнүүдэд үндсэн	
--	--	--	---	--

			цалингийн 15 хувийн нэмэгдлийг олгон ажиллаж байна. Хангамж, үйлчилгээний хэсгийн үйлчлэгчийн ажлын байранд ажиллах ажилтны хомсдол үүсч, батлагдсан орон тооноос нэн дутуу ажиллан нэг үйлчлэгчид ноогдох ажлын ачаалал эрс нэмэгдсэн тул Ерөнхий захирлын 2022 оны Б/313 дугаар тушаалаар 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдэл олгон ажиллаж байна.		
4.3	Эрүүл мэндийн байгууллагуудын эмч ажилтнуудад зориулсан орон сууцны газрын асуудлыг шийдвэрлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах, орон нутгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	-Бодлого төлөвлөлтийн газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	- Эмнэлгийн нийт ажилчидын дунд орон сууцны судалгааг хийж, Худалдаа хөгжлийн банктай хамтран зээлийн үйлчилгээ, орон сууцны зээл буюу ипотекийн зээлийн судалгааг хийж сонирхсон ажилчдад зөвлөгөө зөвлөмж өгч, сургалт зохион байгуулсан. Орон сууцны ипотекийн зээлийг эмнэлэгийн ажилтанд олгуулах хүсэлттэй холбоотой материалуудыг бүрдүүлэн, цаашид үргэлжлүүлэн зээлийг судлан олгуулах ажлыг үргэлжлүүлнэ. - Зуслангийн орон сууц төсөл бичигдэн, газар болон барилгын компанитай хамтран судалгааг хийсэн бөгөөд эдийн засгийн хүндрэлээр түр хойшлогдсон байгааг 2023 онд үргэлжлүүлэн судалж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	95%	
4.4	Эрүүл мэндийн салбарын ажлын онцлог байдал, ачааллыг харгалзан 100 хүртэл ажилтантай бол гэрээгээр, 100-аас дээш ажилтантай төрийн өмчийн эрүүл мэндийн	-Эрүүл мэндийн байгууллагууд -Санхүү, эдийн засгийн газар	Эмнэлгийн ажилтнуудын ажлын онцлог байдал, ачааллыг харгалзан байгууллагад орон тоогоор сэтгэл зүйч ажиллуулах асуудал анхаарал хандуулан “СОНГОН	50%	Мэргэшсэн сэтгэл зүйчийн хомсдоллоос

	байгууллагад орон тооны, хувийн хэвшлийн байгууллагад орон тооны эсхүл гэрээт сэтгэл зүйч ажиллуулах асуудлыг цалингийн сандаа багтаан шийдвэрлэнэ.		ШАЛГАРУУЛАЛТ” зарласан боловч сонгон шалгаруулалтад орох нэр дэвшигчид ирээгүй.		шалтгаалд аг
4.5	Ажил олгогч нь ажлын бус цагаар шөнийн ээлжинд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтанд оройн хоол, өглөөний цайг байгууллагын зардлаар олгоно.	-Эрүүл мэндийн байгууллагууд	Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/124 тушаалаар шөнийн ээлжинд ажилладаг нийт 53 эмнэлгийн ажилтанд оройны хоол, өглөөний цайг байгууллагын зардлаас олгож байна.	100%	
4.7	Салбарын хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүй урлаг, спорт, уулзалт, өдөрлөг, зөвлөгөөн, арга хэмжээг жил бүр бие даан болон талууд хамтран зохион байгуулна.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	2022 оны 6 дугаар сарын 24-26 өдрүүдэд “Эрүүл идэвхитэй амьдрал” арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн сайдын санаачлагаар зохион байгуулагдсан Эрүүл мэндийн салбарын спортын тэмцээнд хамт олноороо амжилттай оролцсон. <u>2022.06 ҮЭХорооны нэрэмжит “Спортын бага наадам”</u>: 2022.12.7-17-нд таван төрөлт /сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартс, шатар/ тэмцээнийг хамтран зохион байгуулж байна. 2022.12.07-нд Шатар, 2022.12.09-нд Дартс болон Ширээний теннис тэмцээн болж, аваргуудаа тодруулсан. 2022.12.17-нд сагсан бөмбөг, гар бөмбөг тэмцээн болохоор бэлтгэл ажил бүрэн хангагдсан.	100%	

4.9	Эрүүл мэндийн байгууллагууд дэргэдээ хүүхдийн цэцэрлэг байгуулан ажиллуулах боломжийг судлан шийдвэрлэхийн төлөө үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран ажиллах, төрөөс хувьсах зардлыг авах замаар ажилтнуудынхаа нийгмийн асуудалд анхаарал хандуулна.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Бодлого төлөвлөлтийн газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн дэргэд 100 хүүхдийн ортой цэцэрлэг шинээр байгуулагдаж Баянзүрх дүүргийн 50 дугаар цэцэрлэгийн салбар бүлэг болсноор 24 дэх байгууллагын цэцэрлэг болон үйл ажиллагаагаа явуулж байна. Одоо цэцэрлэг нийт 100 гаруй хүүхдийг хүлээн авч, дөрвөн бүлэг, 22 багш, ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.	100%	
4.10	Ажилтнуудад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, урамшууллыг хамтын гэрээгээр зохицуулан олгоно.	-Эрүүл мэндийн байгууллагууд	- Нэг удаагийн буцалтгүй тэтгэмж 885,763 төгрөгийг ажилтанд олгосон - Гадаад, дотоодод зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан эмч, сувилагч, мэргэжилтэнд нийт 1,238 ажлын өдрийн тэтгэмжтэй чөлөөг олгосон - Төрсөн аав, ээж, эхнэр нөхөр, хүүхэд нас барсан үед нийт 14 ажилтанд ажлын 5-7 хүртлэх хоногийн нийт 108 ажлын өдрийн тэтгэмжтэй чөлөөг олгосон - Шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10-аас доошгүй өдрийн чөлөөг 6 эрэгтэй ажилтанд олгож, тухайн хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгосон. - Гэр бүлийн гачигдал, шалтгаанаар нийт 156 ажилтанд 991 ажлын өдрийн чөлөө олгосон. 2022 онд эмнэлгийн ажилтны хэрэглээний зээлийн баталгааг баталгаажуулах зорилгоор ХАС	100%	

			банктай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 317 0 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 2,185,000,000 төгрөгийн цалингийн зээл олгоход байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлсэн.		
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙЛАЛ. ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР					
5.1	Эрүүл мэндийн салбарын онцлог, ажлын ачааллыг харьяа байгууллагуудтай хамтран ажлын хэсэг байгуулан судлаж хөдөлмөрийн норм, нормативыг боловсруулахдаа Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтарч ажиллана.	-Нийтийн эрүүл мэндийн газар -Эрүүл мэндийн хөгжлийн төв -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	ЭМНЭЛЭГТ ХАМААРАЛГҮЙ		
5.4	Ажил олгогч нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүнээр хангах болон ажлын цагийг богиносгох зохицуулалт хийнэ.	-Эрүүл мэндийн байгууллагууд	Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын дагуу ажлын хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 147 628 418 төгрөгийг 187 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.	100%	
5.5	Эрүүл мэндийн байгууллага бүр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтныг орон тоогоор болон гэрээгээр ажиллуулна.	-Эрүүл мэндийн байгууллагууд	2021 оноос Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан Ш.Бэлэгдэмбэрэл үндсэн орон тоогоор ажиллаж байна.	100%	
5.6	Ажпын хэт ачаалал, уртасгасан цагаар ажиллах, ажлаас халшрах хамшинж үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор жижүүрийн хуваарийг 12 цагаас хэтрүүлэхгүй байхаар зохицуулалт хийж салбарын хэмжээнд мөрдөн ажиллана.	-Санхүү, эдийн засгийн газар -Эрүүл мэндийн байгууллагууд	- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1,581,542,311 төгрөгийг эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. - Дуудагдан ажилласны хөлс болох 80,503,016 төгрөгийг эмнэлгийн эмч,	100%	

			сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.		
5.7	Эрүүл мэндийн салбарын ажилтнууд өндөр үнэтэй шинжилгээнд хамрагдсан болон хүндээр өвчилсөн тохиолдолд тодорхой нөхцөл байдлыг харгалзан ажиллаж буй байгууллага нь хөнгөлөлт үзүүлнэ.	-Эрүүл мэндийн байгууллагууд	“Эмнэлгийн эрүүл мэндийн ажилтны 2022 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах тухай” эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/28 дугаар тушаалын дагуу Урьдчилан сэргийлэх үзлэгийг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулан ажиллаа. Үзлэгт хамрагдвал зохих 524 ажилтанаас 498 ажилтан лабораторийн болон багажийн шинжилгээнд, 439 хүн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамрагдсан байна. Мөн тайланд онд давхардсан тоогоор 162 ажилтан эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Эдгээрээс 65 ажилтанд яаралтай болон төлөвлөгөөт байдлаар мэс заслын асуудал шийдвэрлэсэн. 2022 онд мэс заслын тасагт ажилчид хамгийн их хэвтсэн бол хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг, ковид, бөөр, дотоод шүүрлийн тасгуудад хэвтэлт бусад тасгуудаас илүү байгаа нь энэ төрлийн өвчин эмгэг давамгайлж байгааг харуулж байна.	100%	
5.10	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг ажлын байранд тасралтгүй зохион байгуулж, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлж, эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллана.	-Нийтийн эрүүл мэндийн газар -Эрүүл мэндийн байгууллагууд	- Ерөнхий захирлын 2022 оны А/59 дүгээр тушаалаар эмнэлгийн “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн болон дүрмийг шинэчлэн баталсан. - ХАА-ны сургалтыг гадны мэргэжлийн байгууллагаас галын сургалт болон ХАА-	100%	

			ны мэдээ мэдээлэл, ХАА-ны сарын аяны хүрээнд 4 тасагт сургалт хийгдэв. Самсунг Бомитой хамран инженерүүд сургалт, Кови Н хөтөлбөрөөр сургалт хийгдсэн. • Тасгуудын ХААЭА-н үйл ажиллагааг хэвшүүлэх өдөр тутамын хөтлөж сургаж, сургалт заавар зааварчилгаа тасгуудад хийгдэж байна • 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр “Хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай” сургалтыг эмнэлгийн нийт 42 удирдах ажилтан, дунд шатны менежер нарт Хөдөлмөрийн хамгаалал, хүний хөгжлийн төв ТББ-ын тэргүүн С.Дуламсүрэн, хуулийн зөвлөх Болорчимэг нар зохион байгуулсан. • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэл сургалтыг Алба 6, тасаг нэгжүүдэд 21 тасагт чиглүүлэх болон удирдлагуудад мэргэжлийн байгууллагаас сургалт хийгдэв.  • Эрүүл мэндийн ажилчдад Галын сургалт болон Эрсдэл, аюулгүй байдлын сургалтыг Гал Импекс ХХК Сургагч багш А.Батмөнх галын	
--	--	--	---	--

			аюулаас сэргийлэх, аюулгүй байдлыг хангах гал унтаарах мэдлэгтэй байх, галын эх үүсвэрээс сэргийлэх, галын хор уршигийг арилгах бэлэн байдлын талаар сургалт зохион байгуулсан. Эрсдлийн үнэлгээ барилга байшин гадна дотно орчны үнэлгээ хийгдээд явж байна. • ХАБЭА- н зүгээс Эрсдэлийн аудит тойрон үзлэг хийхдээ барилга байшингийн гадна ,дотно унах бэртэх эрсдэл,барилгын гадна орчны аюулгүй байдал, тэмдэг тэмдэглэгээ харах, Алба тасаг нэгжүүдэд цахилгааны аюулгүй байдал, галаас сэргийлэх багаж төхөөрөмж, сангийн бүрэн бүтэн аюул байдал, эмнэлгийн тоног төхөөрөмж түүний ашиглаж буй аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуй,ажлын хувцас, халдваргүйтгэл, байгууламж дотор гадна эмх цэгц үзэмж, мэдээллийн самбар хаягжилтыг шалгаж шаардлага тавьж зөвлөмж үүрэг өгч ажиллаж байна. • Барилга байгууламж, Тусгай Тасагт, ХШТБ тасагт галын хөнжил байршуулж, Хүүхдийн цэцэрлэгт галын хор, галын хөнжил байршуулж, Дүрс Оношлогооны тасаг, Эм хангамжын Алба, Авто гараж тасаг, Хангамж үйлчилгээний Алба, ИБА, Радиологийн тасаг, Оношлогооны тасгуудад галын үзлэг аюулгүй ажиллагаа тэмдэг	
--	--	--	---	--

			тэмдэглэгээ, хяналт хийж, галын хор ажиллуулах сургалт зөвлөгөөг өгч, галын мэдээллийн самбар тавьж тойрон үзлэг хийгдэв. • Барилга байгууламжын орчны эрүүл ахуйн аюулгүй байдал нь галын хор 162, галын хайрцаг 54, галын гарц 27, агааржуулалтын решотка 240, ослын гарцын гэрэлтэй тэмдэглэгээ 254 байна • ХАБ-ын зүгээс галын хорыг ажиллуулах ашиглах заавар зааварчилгааөгч, шалгалт авсан Уламжлалын тасгийн ахлах сувилагч Анхмаа, Эм зүй хангамжийн албаны Бямбаа нараас шалгалт авсан.	
--	--	--	--	--





- Байгууламж дахь тоног төхөөрөмжийн ээлжид үзлэгийг Агааржуулалтын инженер Ш.Ариунбилэг, цахилгааны инженер Э.Алтансүх, сангийн инженер Б.Наранцэцэг ХАБ-н ажилтан Ш.Бэлэгдэмбэрэл нар ОҮТ байр болон бусад байрны ажиллаж буй техник тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийж гүйцэтгэв.




Байгууллагад шинээр орсон сувилагч ажилчдад ХАА-ны анхан шатны сургалт ИБА-н танилцуулага сургалт танилуулж зааварчилгаа хийгдсэн. Байгууллагад шинээр ирсэн эмч, резидент эмч, сувилагч ажилтан нарт ХАА-ны сургалт анхан шатны заавар сургалт хийгдсэн





- Төв байр болон 50 ортын Лифтэнд засвар үйлчилгээ хийхэд аюулгүй байдлыг шалгаж, Лифтэнд тойрон үзлэг хийж, хонгилд дахь хог хаягдалыг цэвэрлүүлэв. Мөн техникийн ажиллагааг хянаж, удирдлага хяналт, хаалганы мэдрэгч солиулсан
- Лифтний хонгил, бүхээгний зам, торос, үйлчилгээ хийгдэхэд хяналт тавьж, зөвлөмж зөвөлгөө өгөгдөв.



- Шалгалтын явцад Байгууллагын гадна орчин гэрэлтүүлэггүй, замын тэмдэглэгээг сайжруулах, гарцын тэмдэглэгээ таних тэмдэг байхгүй, зүг

			чиг заасаг хаяг тэмдэглэгээ байхгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тохирсон замын тэмдэглэгээ, барилга байгууламжын гадна дотор хана, хананы фасат унасан, цууралттай, сүлжээ болон цахилгаан утас татсан унжсан, кислород болон баллон хүлээн авах,, ачиж буулгахад зогсоол байхгүй эрсдэл ихтэй, тамхины цэг байгуулах шаардлагатай / цэг байхгүй / хог хаягдал ихтэй, байгууламжын дотор өрөөнүүдэд галын болон цахилгаан аюулгүй байдлын мэдээлэх самбар хаяг хийгдэх, тоног төхөөрөмжийн кабель утаснууд эмх замбааргүй, интернетийн сүлжээний утаснууд далдлагч болон холбосон кабелууд ил эрсдэл доголдол гарах өндөр учир аюулгүй байдлыг хангах шаардлага хүргүүлж шийдвэрлэсэн байна.		
5.12	Үйлдвэрлэлийн осол гаргаагүй болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг үлгэр жишээ зохион байгуулсан, ажиллагсдынхаа хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгааг сайжруулсан, ҮЭ-ийн байгууллагын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажилладаг байгууллагын ажил олгогчийг урамшуулна.	-Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осол, хордлого бүртгэгдээгүй.	100%	
5.14	Шөнийн ээлжнээс буусан ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол үргэлжлүүлэн хурал зөвлөгөөн, сургалт зэрэг үйл ажиллагаанд	-Эрүүл мэндийн байгууллагууд	Шөнийн ээлжнээс буусан ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол үргэлжлүүлэн хурал зөвлөгөөн, сургалт зэрэг үйл ажиллагаанд	80%	Шаардлагатай тохиолдолд

	хамрагдахыг байгууллагын зүгээс шаардахгүй байна.		хамрагдахыг байгууллагын зүгээс шаардалгүй ажилласан.		хамруулдаг
5.15	Эмнэлгүүдийн яаралтай тусламж, хүлээн авах тасагт эрсдлийн үнэлгээ хийлгэж, эмзэг бүлгийн иргэд, донтох эмгэгтэй, зан төрхийн өөрчлөлтөд орсон үйлчлүүлэгч эмч ажилтанд аюултай үйлдэл хийх эрсдэлээс сэргийлж тухайн орчныг камержуулах, харуул хамгаалалтын дэмжлэг үзүүлэх, нэмэгдэл урамшуулалд хамруулан тогтвортой ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлнэ.	-Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар, -Санхүү, эдийн засгийн газар -Эрүүл мэндийн байгууллагууд	Эмнэлгийн яаралтай тусламж, хүлээн авах тасагт эмзэг бүлгийн иргэд, донтох эмгэгтэй, зан төрхийн өөрчлөлтөд орсон үйлчлүүлэгч эмч, ажилтанд аюултай үйлдэл хийх эрсдэлээс сэргийлэх зорилгоор орчныг камержуулж, харуул хамгаалалтын ажилтанг 24 цагаар ажиллуулж байна.	100%	
ЗУРГАА. ХАМТЫН АЖИЛЛАГАА, МЭРГЭЖИЛ, МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР					
6.1	Хөдөлмөрийн харилцаа, эрүүл мэндийн болон холбогдох хууль эрх зүйн асуудлаар сургалт, семинар, уулзалт зөвлөгөөнийг хамтран болон дангаар зохион байгуулж, эмнэлгийн мэргэжилтэнд багц цаг олгоно.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	ЭМНЭЛЭГТ ХАМААРАЛГҮЙ		
6.3	Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцаатай холбогдсон хууль эрх зүйн гарын авлага бэлтгэн гаргаж өмчийн хэлбэр харгалзахгүй түгээнэ.	-Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	ЭМНЭЛЭГТ ХАМААРАЛГҮЙ		
6.4	Эрүүл мэндийн салбарын холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос 2023 оны улсын төсөв хэлэцэхтэй холбоотойгоор “Төрийн албан хаагчдаас цалин хөлс, хүний нөөцийн судалгаа” авсан.	100%	

	холбооны саналыг албан ёсоор бичгээр хүргүүлэн авч, тусгана.				
6.5	Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх эрх ашгийг хамгаалах, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах талаар талууд нэгдмэл байр суурьтай хамтран ажиллана	-Бодлого төлөвлөлтийн газар -Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны хөдөлмөрлөх эрх ашгийг хамгаалах, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг сайжруулах талаар Эмнэлгийн захиргаа болон эмнэлгийн үйлдвэрчний эвлэл нэгдмэл байр суурьтай хамтран ажиллаж 2022 онд Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам боловсруулах, батлуулах “Ажлын хэсэг”-т эмнэлгийн үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөллийг оролцуулсан. Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны А/51 дүгээр тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг батлан, мөрдөн ажиллаж байна.	100%	
6.7	Тухайн байгууллага нь төсвийн хуваарилалт, зарцуулалтын ил тод байдлыг хангах, хяналт тавихад бүх шатны үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоог хангаж, мэдээлэл солилцоно	-Эрүүл мэндийн байгууллагууд	Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нь эмнэлгийн Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон бөгөөд төсвийн хуваарилалт, зарцуулалтын ил тод байдлыг хангах, хяналт тавах зорилгоор бүхий л асуудлыг шийдвэрлэхэд оролцсон.	100%	
6.11	Эрүүл мэндийн ажилтны нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг өргөх талаар хамтран ажиллаж, эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийн арга хэмжээ, “Алтан чагнуур” ёслолын ажиллагааг Монголын эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Эрүүл мэндийн яам, Ажил олгогчийн төлөөлөлтэй хамтран зохион байгуулна.	-Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо -Төрийн захиргааны удирдлагын газар	Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос уламжлал болгон зохион байгуулдаг “Алтан чагнуур” шагналд эмнэлгийн мэргэжилтнүүдээс нэр дэвшүүлж Яаралтай тусламжийн чиглэлээр тус эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч Ж.Уламсайхан шагнагдсан.	100%	

6.15	Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх талаар Аймгийн эрүүл мэндийн газар, тухайн аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны салбар зөвлөлтэй, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Монголын эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан хэрэгжүүлнэ.	-Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо -Төрийн захиргааны удирдлагын газар	ЭМНЭЛЭГТ ХАМААРАЛГҮЙ		
ДОЛОО. ХЭЛЭЛЦЭЭРИЙГ МӨРДӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР					
7.1	Энэхүү хэлэлцээр нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсны дараа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж, бүртгүүлсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.	-Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Төрийн захиргааны удирдлагын газар	Хэлэлцээрийг хүлээн авч эмнэлгийн тусламж, хөдөлмөр эрхлэлтийн харилцаандаа мөрдөн ажиллаж байна.	100%	
7.2	Хамтын хэлэлцээрт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг талууд жил бүр хамтран боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	Эрүүл мэндийн яамнаас боловсруулан, баталсан төлөвлөгөөг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.	100%	
7.3	Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримталсан журмын дагуу шийдвэрлэнэ.	-Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо -Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны	ЭМНЭЛЭГТ ХАМААРАЛГҮЙ		

		үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо			
7.4	Хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлтэнд талууд хамтран хяналт тавьж ажиллана. Хэлэлцээрийн биелэлтийг хамтарсан ажлын хэсэг гарган бүтэн жилээр дүгнэж, нийтэд мэдээлнэ.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	Хэлэлцээрийн хэрэгжилт, биелэлтийг эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хороотойгоо хамтран тайлагнасан.	100%	
7.5	Цалин хөлс, нийгмийн хамгаалалтай холбоотой энэхүү хэлэлцээрээр тогтоосон доод хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг тухайн байгууллага хамтын гэрээгээрээ зохицуулна.	-Эрүүл мэндийн байгууллагууд	Хэлэлцээрээр тогтоосон доод хэмжээг нэмэгдүүлэх талаар эмнэлгийн “Хамтын гэрээ”-дээ бүрэн тусгахын тулд Хамтын гэрээ байгуулах ажлын хэсгийн өөлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100%	
7.6	Салбарын хамтын хэлэлцээр (хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хамтын ажиллагаа, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх)-ийн биелэлтийг хянах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хамтарсан удирдамжийн хүрээнд зөвлөн туслах үзлэг, хяналт хийнэ.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	ЭМНЭЛЭГТ ХАМААРАЛГҮЙ		
7.7	Энэхүү хамтын хэлэлцээр нь дараагийн хамтын хэлэлцээр байгуулагдах хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.	-Төрийн захиргааны удирдлагын газар -Монголын эрүүл мэндийн	Хамтын хэлэлцээрийг дараагийн хамтын хэлэлцээр байгуулагдах хүртэл мөрдөн ажиллана.	100%	

		ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо			
7.8	Эрүүл мэндийн яам, Монголын эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, шинэчлэгдэх нь энэхүү хэлэлцээр дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн залгамжлагчид нь хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.	-Төрийн захиргааны удирдлагын газар- -Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо	Эмнэлэг, эмнэлгийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хорооны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, шинэчлэгдэх нь энэхүү хэлэлцээр дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн залгамжлагчид нь хэлэлцээрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.	100%	